

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ /2012 ОН/**

Сүхбаатар 2012 он

Гарчиг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол

1) Хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай.....	5
2) Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчийг нөхөн сонгох тухай.....	6
3) Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай.....	7
4) Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай.....	8-9
5) Анхдугаар хуралдааны дэг батлах тухай.....	10-15
6) Аймгийн ИТХ-ын даргыг сонгох тухай.....	16
7) Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг сонгох тухай.....	17
8) Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай.....	18
9) Аймгийн ИТХ-ын хороодыг байгуулах тухай.....	19
10) Аймгийн 2011 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
11) Аймгийн 2013 оны төсвийн төсөл.....	21-36
12) Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай.....	37-40
13) Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай.....	41-42

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол

1) Агнуурын амьтан агнах, барихтай холбогдсон зарим үйл ажиллагааг хориглох тухай.....	43
2) Зөвшөөрөл олгох тухай	44
3) Орон нутгийн шилдэг удирдагч шагналд уламжлах тухай.....	45
4) Тэмцээн зохион байгуулах тухай.....	46
5) 2012 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай.....	47-55
6) Журамд өөрчлөлт оруулах тухай.....	56
7) Сүм байгуулах зөвшөөрөл олгох тухай.....	57
8) Баянгол сумыг Улсын тэргүүний /загвар/ сумаар шалгаруулах саналыг уламжлах тухай.....	58
9) Газар олголтыг түр зогсоох тухай.....	59
10) 2012 оныг “Өрхийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг эрчимжүүлэх жил” болгон зарлах тухай.....	60
11) Төлөвлөгөө батлах тухай.....	61-64
12) Үйлчилгээний хөлсний жишиг үнэлгээ тогтоох тухай.....	65-66
13) Тогтоолд өөрчлөлд оруулах тухай.....	67
14) 2012 онд агнах, барих ан амьтны тоо хэмжээг тогтоох тухай.....	68-69
15) Агнуурын зарим амьтныг агнах, барихыг хориглох тухай.....	70
16) Сэлэнгийн долгио чуулгын талаар авах зарим арга хэмжээний тухай.....	71
17) Зөвшөөрөл олгох тухай.....	72
18) Зарим эхчүүдийг Алдарт эхийг одонгоор шагнуулах тухай.....	73-83
19) Журам батлах тухай.....	84-89
20) Хугацаа сунгах тухай.....	90
21) Зөвшөөрөл олгох тухай.....	91

22) Үндсэн хөрөнгүүдийг шилжүүлэх тухай.....	92-94
23) Үндсэн хөрөнгө актлах тухай.....	95-96
24) Нэрэмжит болгох тухай.....	97
25) Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай.....	98-103
26) Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай.....	104
27) Ойгоос нэмж бэлтгэх модны дээд хэмжээ батлах тухай.....	106-106
28) Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай.....	107
29) Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай.....	108
30) Хүдэр сумын “Хүдэр дулаан”, Сүхбаатар сумын “Сэлэнгэ эрчим хүч” ОНӨААТҮГ-уудыг хувьчлах тухай.....	109-110
31) Ээлжит бус хуралдаан хуралдуулах тухай.....	111
32) Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч, төлөөлөгчдөд урамшуулал олгох журам батлах тухай.....	112-113
33) Сумын ИТХ-ын Тэргүүлэгч, төлөөлөгчдөд урамшуулал олгох журам батлах тухай.....	114-115
34) Тэргүүлэгчдийн ажлын албаны орон тоо тогтоох тухай.....	116-117
35) Хэрэглээний мод бэлтгэх зөвшөөрөл олгох тухай.....	118
36) Газрыг тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжих тухай.....	119-121
37) Ашиглалтгүй барилгыг шилжүүлэх тухай.....	122-123
38) Ашиглалтгүй барилгыг актлах тухай.....	124-125
39) Барилга шилжүүлэн барих зөвшөөрөл олгох тухай.....	126
40) Ашиглалтгүй авто тээврийн хэрэгслүүдийг дуудлага худалдаагаар худалдах тухай.....	127-128
41) “Сэлэнгэ БИТ” ОНӨААТҮГ газрыг татан буулгах тухай.....	129-131
42) Хөрөнгө шилжүүлэх тухай.....	132-133
43) Ой тэмдэглэх тухай.....	134
44) Ой тэмдэглэх тухай.....	135
45) Ажлын хэсэг байгуулах тухай.....	136
46) Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнах тухай.....	137
47) Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжлөн шагнах тухай.....	138
48) Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнах тухай.....	139-140
49) Аймгийн Сонгуулийн хороо байгуулах тухай.....	141
50) Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн тоог гаргах тухай.....	142-143
51) Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн тоог гаргах тухай.....	144-146
52) Орон нутгийн өмчийн албаны даргыг томилох тухай.....	147
53) Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай.....	148
54) Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай.....	149
55) Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги төлөвлөгөө батлах тухай.....	150-154
56) Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг батлах тухай.....	155-157
57) Зардлын дээд хэмжээ тогтоох тухай.....	158-159
58) Өмч шилжүүлэхийг зөвшөөрөх тухай.....	160-161
59) Өмч шилжүүлэхийг зөвшөөрөх тухай.....	162-163

60)Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай.....	164-165
61)Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай.....	166
62)Ажлын хэсэг томилох тухай.....	167
63)Төлөвлөгөө батлах тухай.....	168-174
64)Анхдугаар хуралдаан зарлах тухай.....	175
65)Хуралдаан зарлах тухай.....	176
66)Аймгийн аудитын газрын тайлангийн тухай.....	177
67)Хөтөлбөр батлах тухай.....	178-190
68)Сум дундын ойн анги байгуулах тухай.....	191-197

_____oOo_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 03 сарын 12-ны өдөр

Дугаар 76

Сүхбаатар

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, үр дүнг хэлэлцээд “Иргэнээ дэмжиж өрх гэрээ тэтгэе, үйлдвэрлэлээ хөгжүүлж эх нутгаа хөгжүүлэе” эрхэм зорилтын хүрээнд аймаг, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн жигд хөгжлийг ханган жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг 2008 оныхоос 0,3, ядуурлын түвшинг 1,0 хувиар бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүнийг 32,8 хувиар өсгөн Монгол Улсын Засгийн газраас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг ханган биелүүлж, сүүлийн 3 жил дараалан Монгол Улсын “Шилдэг аймаг”-аар шалгарсан зэрэг ололт амжилтыг сайшаан тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг “ХАНГАЛТТАЙ” гэж үнэлсүгэй.

Хоёр.Аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбатад ДААЛГАХ нь:

2.1.Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хэрэгжилт нь удаашралтай байгаа зарим ажил, арга хэмжээг үлдсэн хугацаанд бүрэн биелүүлэх.

2.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар аймгийнхаа нийт иргэдэд мэдээлэх, тайлагнах ажлыг зохион байгуулах.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 03 сарын 12-ны өдөр

Дугаар 78

Сүхбаатар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчийг нөхөн сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “б”-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээр Лувсаннавааны Амарсайханыг нөхөн сонгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 08 сарын 08-ны өдөр

Дугаар 79

Сүхбаатар

Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “г”, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн саналаар Содын Бүрэнбатыг Сэлэнгэ аймгийн Засаг даргад нэр дэвшүүлсүгэй.

2. Содын Бүрэнбатыг аймгийн Засаг даргаар томилуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад санал болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 03-ны өдөр

Дугаар 01

Сүхбаатар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.1-ийн “а”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөр сонгогдсон хавсралтад дурьдсан 36 төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсүгэй.

ХУРАЛДААНЫ ДАРГА

Д.ЦЭЛЭГМАА

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД
СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН НЭРС**

1. Пүрэвдоржийн Батсайхан
2. Батсуурийн Энхбат
3. Жамъяндоржийн Наранцэцэг
4. Жалсрайн Баярмагнай
5. Цэндийн Рэгзэдмаа
6. Базарын Цээпилдорж
7. Содын Бүрэнбат
8. Сэнгээгийн Эрдэнэбаяр
9. Дэлгэр-Очирын Баатаржав
10. Доржпаламын Өлзийбадрах
11. Бандийн Болд
12. Шархүүгийн Оргил
13. Доржийн Бадрах
14. Гаршаавын Бямбаа
15. Чүлтэмсүрэнгийн Жамбалнямбуу
16. Мижиддоржийн Үүрийнтуяа
17. Гонгоржавын Батцэнгэл
18. Нацагдоржийн Гэрэлт-Од
19. Лувсаннавааны Амарсайхан
20. Баянгийн Пүрэвсүрэн
21. Долгорын Пүрэвдорж
22. Чойжамцын Жаргалсайхан
23. Марусягийн Баярбаатар
24. Баасансүрэнгийн Нарантуяа
25. Жавзангийн Санжжав
26. Цээлхаажавын Эрдэнэчимэг
27. Жамсрангийн Отгонхүү
28. Донровын Цэлэгмаа
29. Дониогийн Цогт-Очир
30. Батхүүгийн Баярхүү
31. Содовын Энхтайван
32. Чүлтэмийн Дэмбэрэлсайхан
33. Найдангийн Батдорж
34. Дэмбэрэлийн Солонго
35. Чимэддоржийн Даваасүрэн
36. Солийн Нина

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 03-ны өдөр

Дугаар 02

Сүхбаатар

Анхдугаар хуралдааны дэг батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас
ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдааны дэгийг
хавсралтаар баталсугай.

ХУРАЛДААНЫ ДАРГА

Д .ЦЭЛЭГМАА

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АНХДУГААР ХУРАЛДААНЫ ДЭГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг нээх, удирдах, анхдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг оруулах, нэр дэвшүүлэх, хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахад энэ дэгийг мөрдөж баримтална.

1. Анхдугаар хуралдааныг нээх

1.1. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д зааснаар Анхдугаар хуралдааныг шинээр сонгогдсон Төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь нээж удирдана.

2. Анхдугаар хуралдааны хэлэлцэх асуудал, түүний дарааллыг батлах

2.1. Анхдугаар хуралдаанаар дараах асуудлыг заавал хэлэлцэнэ.

-Аймгийн ИТХ-ын шинээр сонгогдсон Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

-Аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийг сонгох

-Аймгийн ИТХ-ын хороо, түр хороо байгуулах, хорооны дарга, бүрэлдэхүүнийг сонгох

-Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх

2.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг ил санал хураалтаар Төлөөлөгчдийн олонхийн саналаар батална.

3. Шинээр сонгогдсон Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх

3.1. Аймгийн ИТХ-ын сонгуулийн дүн, шинээр сонгогдсон Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай тогтоолын төслийг Аймгийн Сонгуулийн хорооны дарга оруулна.

3.2. Аймгийн ИТХ-ын сонгуулийн дүн, Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай тогтоолын төсөлтэй холбогдуулан төлөөлөгчид асууж танилцана.

3.3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шинээр сонгогдсон Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай тогтоолын төслийг ил санал хураалтаар батална.

3.4. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулна.

4.Анхдугаар хуралдааны дэгийг батлах

4.1.Хуралдааны дэгийн төслийг Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын алба бэлтгэж Төлөөлөгчдөд урьдчилан тараана.

4.2.Хуралдааны дэгийн төсөлтэй холбогдуулан төлөөлөгчид асууж тодруулан хариулт авч болох бөгөөд асуултанд Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын алба хариулт өгөх үүрэгтэй.

4.3.Дэгийн төсөлд шинээр нэмж оруулах, хасах, өөрчлөх саналаа Төлөөлөгчид дэгийн зүйл хэсэг бүр дээр тодорхой томъёоллоор гаргана.

4.4.Дэгийн төсөлд нэмж оруулах, хасах, өөрчлөх талаар Төлөөлөгчдөөс гаргасан зарчмын өөр саналыг ил санал хураалтаар шийдвэрлэж Төлөөлөгчдийн олонхийн санал авсан асуудлыг дэгийн төсөлд тусгана.

4.5.Хуралдааны дэгийг батлах тухай тогтоолын төслийг батлуулна.

5.Тооллогын комисс байгуулах.

5.1.Хурлын дарга, Тэргүүлэгчдийг сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх, Хурлын хорооны даргыг сонгох, бүрэлдэхүүнийг батлах, санал хураалтыг явуулж зохион байгуулах, дүнг гаргах тооллогын комиссыг Хурлын төлөөлөгчдийн дотроос дарга, 2 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ил санал хураалтаар сонгоно.

5.2.Тооллогын комиссын бүрэлдэхүүнд орсон төлөөлөгч Хурлын дарга, Тэргүүлэгчид, Засаг дарга, Хурлын хорооны даргад нэр дэвшвэл түүний оронд өөр төлөөлөгчийг сонгоно.

5.3.Тооллогын комисс нь санал хураалтыг зохион байгуулан явуулж, дүнг гарган хуралдаанд танилцуулна.

6.Хурлын даргыг сонгох

6.1.Хурлын даргыг Хурлын Төлөөлөгчдийн дотроос нэр дэвшүүлэн сонгоно.

6.2.Сонгуулийн үр дүнгээр тухайн хуралд хамгийн олон суудал авсан нам эвсэл Хурлын даргад эхэлж нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшсэн хүний талаар товч танилцуулна.

6.3.Хурлын Төлөөлөгч Хурлын даргад өөрийн болон өөр бусад төлөөлөгчийн нэрийг дэвшүүлж болох бөгөөд нэр дэвшүүлсэн хүнийхээ талаар товч танилцуулна.

6.4.Хурлын Төлөөлөгчид Хурлын даргад нэр дэвшсэн хүний талаар нэр дэвшүүлсэн этгээдээс, мөн нэр дэвшсэн хүнээс асуулт асууж болно.

6.5.Хурлын даргад нэр дэвшүүлсэн этгээд болон нэр дэвшигч асуултанд хариулна.

6.6.Хурлын даргад нэг хүний нэр дэвшсэн бол санал хураалтыг илээр, 2 ба түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол санал хураалтыг нууцаар явуулна.

6.7.Тооллогын комисс санал хураалтыг зохион байгуулж явуулна.

6.8.Санал хураалтын дүнг тооллогын комиссын дарга танилцуулна.

6.9.Олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан төлөөлөгчийг Хурлын даргаар сонгогдсонд тооцож тогтоолыг батлуулна.

6.10. Санал хураалтаар аймгийн ИТХ-ын даргад нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал авч чадаагүй тохиолдолд хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчийг үлдээн дахин санал хураалт явуулна.

7.Хурлын Тэргүүлэгчдийг сонгох

7.1.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг Хурлын даргыг оролцуулан 7-11 хүний бүрэлдэхүүнтэй сонгоно.

7.2.Тэргүүлэгчдийн тоог хуульд заасан /7-11/ тоонд багтаан төлөөлөгчдийн олонхийн саналаар ил санал хураалтаар батлуулна.

7.3.Хурлын Тэргүүлэгчдэд аймгийн ИТХ-д хамгийн олон суудал авсан нам эхэлж нэр дэвшүүлэх бөгөөд хуралд суудалтай бусад нам, Хурлын Төлөөлөгч нэр дэвшүүлж болно.

7.4. Хурлын Тэргүүлэгчдэд нэр дэвшигчээс төлөөлөгчид асуулт асууж болно.

7.5.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг сонгох санал хураалтыг нэр дэвшсэн хүн тус бүрээр илээр эсвэл нууцаар явуулна. /Санал илээр эсвэл нууцаар хураах асуудлыг Төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ./

7.6.Санал хураалтын дүнг тооллогын комисс гаргаж танилцуулна.

7.7.Хуралд оролцсон Төлөөлөгчдийн хамгийн олон санал авсан энэ дэгийн 7.2-т тогтоосон тооны Төлөөлөгчдийг Хурлын Тэргүүлэгчдээр сонгогдсонд тооцно.

7.8.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг сонгох тухай тогтоолын төслийг ил санал хураалтаар батлуулна.

8.Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх

8.1.Аймгийн Засаг даргад тухайн хуралд хамгийн олон санал авсан намын бүлэг эхэлж нэр дэвшүүлэх бөгөөд хуралд суудалтай бусад нам эвслийн бүлэг нэр дэвшүүлж болно.

8.2.Аймгийн Засаг даргад Хурлын төлөөлөгч нэр дэвшүүлж болно.

8.3.Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлсэн нам эвслийн бүлэг, Хурлын төлөөлөгч нэр дэвшүүлсэн хүнийхээ талаар товч танилцуулна.

8.4.Хурлын төлөөлөгчид нэр дэвшигчийн талаар нэр дэвшүүлсэн этгээдээс болон нэр дэвшигчээс асуулт асууж болно.

8.5.Асуултанд нэр дэвшүүлсэн нам эвслийн бүлэг, төлөөлөгч эсвэл нэр дэвшигч өөрөө хариулна.

8.6.Төлөөлөгчид аймгийн Засаг даргад нэр дэвшигчийн талаар саналаа хэлнэ.

8.7. Аймгийн Засаг даргад нэг хүний нэр дэвшүүлсэн бол санал хураалтыг илээр, 2 ба түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол санал хураалтыг нууцаар явуулна.

8.8.Санал хураалтын дүнг тооллогын комисс гаргаж танилцуулна.

8.9. Хуралд оролцсон төлөөлөгчдийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг аймгийн Засаг даргаар томилуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад санал болгож тогтоол гаргана.

8.10.Хэн нь ч олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчийг үлдээн дахин санал хураалт явуулна.

9. Аймгийн ИТХ-ын бодлогын хороо байгуулах тухай

9.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бодлого үйл ажиллагааныхаа шаардлагатай салбар чиглэлээр Хурлын хороо байгуулна.

9.2. Ямар салбар чиглэл хариуцсан хэдэн хороо байгуулах талаарх саналаа ИТХ-ын дарга хуралдаанд оруулна.

9.3. Хурлын хорооны тоо, нэрийн талаар төлөөлөгчид санал гаргаж болно.

9.4. Хурлын хороо байгуулах асуудлыг ил санал хураалтаар төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

9.5. Хурлын хорооны бүрэлдэхүүнийг төлөөлөгчдийн өөрсдийнх нь саналыг харгалзан ил санал хураалтаар батална.

9.6.Хурлын хорооны даргыг төлөөлөгчдийн дотроос нэр дэвшүүлэн ил санал хураалтаар сонгоно.

10. Нам, эвслийн бүлэг

10.1. Аймгийн ИТХ-д 6-аас доошгүй төлөөлөгчтэй нам, эвсэл бүлэг байгуулж болно.

10.2. Нам, эвслийн бүлгийг тухайн нам эвслээс сонгогдсон төлөөлөгчид хуралдан байгуулж ахлагчаа сонгоно.

10.3. Нам, эвсэл бүлэг байгуулсан шийдвэрийг тухайн нам, эвслийн бүлгийн ахлагч Хурлын даргад өгнө. Бүлэг байгуулах шийдвэрт тухайн нам, эвслийн бүлэгт нэгдсэн төлөөлөгчдийн нэрийг хавсаргасан байна.

10.4. Хуралдааны дарга нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, тухайн бүлэгт нэгдсэн төлөөлөгчдийн нэрийг уншиж сонгоно.

11.Хуралдааны үйл ажиллагаанд баримтлах нийтлэг зүйл

11.1. Хуралдааны үйл ажиллагаа хууль дээдлэх, дэгээ сахих асуудлыг чөлөөтэй хэлэлцэн цөөнхийн саналыг хүндэтгэж олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.

11.2. Хуралдааныг нээлттэй явуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл хаалттай явуулж болно. Хуралдааныг хаалттай явуулах асуудлыг төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

11.3. Нам, эвслийн бүлэг тухайн хэлэлцэж буй асуудлаар шаардлагатай гэж үзвэл хуралдаанаас 1 удаа 2 хүртэл цагаар түр завсарлага авч болно.

11.4. Хурлын төлөөлөгч зориудаар хуралдаанд оролцохгүй байх, түүнийг орхиж гарахыг хориглох бөгөөд зориудаар оролцоогүй буюу орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцно.

11.5. Хуралдаанаар хэлэлцэж буй асуудал бүр дээр төлөөлөгч 7 минут үг хэлж болох бөгөөд зарчмын өөр саналтай төлөөлөгч эхний удаа 5 минут, дахин 1 удаа 3 минутаас илүүгүй үг хэлж болно.

11.6. Үг хэлж саналаа гаргаж байгаа төлөөлөгчийн үгийг таслах, эсэргүүцэхийг хориглоно.

11.7. Хурлын хуралдааныг 2 цаг тутамд 15 минутын завсарлагатай явуулна.

11.8. Хурлын төлөөлөгч хуралдаанд оролцохдоо дараах журмыг баримтална.

Үүнд:

11.8.1. Гарах, орох, үг хэлэхдээ хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авах.

11.8.2. Хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариу авах, үг хэлэх.

11.8.3. Хэлэлцэж байгаа асуудлаар санал гарган, тодорхой томъёоллоор санал хураалгах.

11.8.4. Хуралдааны дэгийг чанд сахих

12.Хуралдаан даргалагчийн эрх үүрэг

12.1. Хуралдааныг дэгийн дагуу удирдан явуулж төлөөлөгчдөөс дэгээ сахин биелүүлэхийг шаардах.

12.2.Төлөөлөгчдөд үг хэлэх зөвшөөрөл олгож үг хэлэх хугацааг чанд мөрдүүлэх.

12.3. Санал хураалтыг томъёолон явуулах, санал хураалтын дүнг мэдээлэх.

12.4. Хуралдааны шийдвэрийг уншиж сонсгон батлуулах.

12.5. Хуралдааны баримт бичгийг үнэн зөв гаргаж баталгаажуулах.

12.6. Хуралдааны дэг зөрчсөн төлөөлөгчид анхааруулах, сануулах.

_____оОо_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 03-ны өдөр

Дугаар 03

Сүхбаатар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргыг сонгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “б”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн 100 хувийн саналаар Жавзангийн Санжжавыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгосугай.

ХУРАЛДААНЫ ДАРГА

Д.ЦЭЛЭГМАА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 03-ны өдөр

Дугаар 04

Сүхбаатар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийг сонгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “б”, 19 дүгээр зүйлийн 19.1, 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тоог 11 байхаар тогтоож доорхи Төлөөлөгчдийг Тэргүүлэгчдээр сонгосугай. Үүнд:

- 1.Жавзангийн Санжжав
- 2.Содын Бүрэнбат
- 3.Баасансүрэнгийн Нарантуяа
- 4.Чойжамцын Жаргалсайхан
- 5.Баянгийн Пүрэвсүрэн
- 6.Батсуурийн Энхбат
- 7.Гаршаавын Бямбаа
- 8.Шархүүгийн Оргил
- 9.Пүрэвдоржийн Батсайхан

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 03-ны өдөр

Дугаар 05

Сүхбаатар

Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “г”, 19 дүгээр зүйлийн 19.1, 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн 100 хувийн саналаарСодын Бүрэнбатыг аймгийн Засаг даргад нэр дэвшүүлсүгэй.

2.С.Бүрэнбатыг аймгийн Засаг даргаар томилж өгөхийг Монгол Улсын Ерөнхий сайдад санал болгосугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 03-ны өдөр

Дугаар 06

Сүхбаатар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Бодлогын хороодыг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “в”, 19 дүгээр зүйлийн 19.1, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд доорх Бодлогын хороодыг байгуулсугай.

1. Төсвийн бодлогын хороо
2. Үйлдвэр, хөдөө аж ахуйн бодлогын хороо
3. Нийгмийн бодлогын хороо
4. Нутгийн удирдлага, хууль хяналтын бодлогын хороо /ёс зүйн дэд хороотой/
5. Байгаль орчин, уул уурхай, газрын бодлогын хороо
6. Эдийн засаг, хөгжлийн бодлогын хороо

ДАРГА

Ж.САНЖЖАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 сарын 04-ний өдөр

Дугаар 08

Сүхбаатар

Аймгийн 2013 оны төсөв батлах тухай

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 11, 13 дугаар зүйлүүдийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн 2013 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

	Сэлэнгэ аймгийн төсвийн орлого бүгд	60 042 921,2
1.	Урсгал орлого	60 042 921,2
1.1	Татварын орлого	12 980 042,0
1.1.1	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвар	8 800 000,0
1.1.2	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	700 000,0
1.1.3	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-550 000,0
1.1.4	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ, хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар	115 000,0
1.1.5	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	490 000,0
1.1.6	Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	60 000,0
1.1.7	Газрын төлбөр	420 000,0
1.1.8	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	2 945 042,0
1.1.9	Бусад татвар, төлбөр хураамж	
1.2	Татварын бус орлого	46 000,0
1.2.1	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг	
1.2.2	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр	
1.2.3	Хүү, торгуулийн орлого	

1.2.4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	46 000,0
1.2.5	Хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого	
2.	Хөрөнгийн орлого	0,0
2.1	Хөрөнгө борлуулсны орлого	
2.2	Өмч хувьчлалын орлого	
3.	Тусламжийн орлого	47 016 879,2
3.1	Хандив тусламжийн орлого	
3.2	Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	3 293 235,7
3.3	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	8 476 000,0
3.4	Тусгай зориулалтын шилжүүлэг	35 247 643,5

Гурав.Аймгийн 2013 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай.

/мянган төгрөг/

3.1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	242 702,8
3.1.1.	Урсгал зардлын дээд хэмжээ	242 702,8
3.1.2.	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	
3.2.	Аймгийн ерөнхий аудитор	171 394,0
3.2.1.	Урсгал зардлын дээд хэмжээ	171 394,0
3.2.2.	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	
3.3.	Аймгийн Засаг дарга	59 583 723,2
3.3.1.	Урсгал зардлын дээд хэмжээ	59 252 973,2
3.3.1.1.	Үүнээс: Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ	9 337 618,2
3.3.1.2.	Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	5 085 600,0
3.3.1.3.	Сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ	35 247 643,5
3.3.2.	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	330 750,0
3.4.	Орон нутгийн өмчийн албаны дарга	45 101,2
3.4.1.	Урсгал зардлын дээд хэмжээ	45 101,2
3.4.2.	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	

Долоо.Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мян төгрөг/

1	Äèðàí áóëàã	462 921,1
2	Áàðóóí áçðýí	358 636,9
3	Áàýí ã ë	443 838,7
4	Åð°°	501 674,7
5	Æàâðëàí ò	330 763,1
6	Ççí áçðýí	422 707,4
7	Ì àí ààë	1 341 438,3
8	Î ðõí í	302 499,8
9	Î ðõí í òóóë	447 268,0
10	Ñàí ò	333 963,8
11	Ñàéðàí	764 944,8
12	Ñçðáààðàðð	1 799 795,7
13	Òçø èã	194 811,3
14	Õäýð	298 614,7
15	Öóø ààò	332 871,8
16	Öàãàí í óóð	414 357,6
17	Øààì àð	586 510,5
	НИЙТ ДҮН	9 337 618,2

Найм.Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих зардлыг сум, аймгийн төсөвтэй харьцдаг байгууллага бүрээр хуваарилан 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Ес. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Арав. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Арван нэг.Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, баталсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ ТӨСВИЙН ХУУЛИАР ТУС АЙМАГТ БАТАЛСАН
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ**

	Сумын нэр	Ерөнхий боловсролын сургууль	Хүүхдийн цэцэрлэг	Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	Сумын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Номын сан	Соёлын төв	Театр чуулга	Соёлын ордон	Биеийн тамир спорт клуб цогцолбор	Суурь зардалын дүн
1	Àèðàí áóèàã	647 969,5	485 963,4		177 896,2	0,0	0,0	55 207,8				1 367 036,9
2	Áàðóóí á¿ðýí	503 101,4	242 647,0		171 856,8	0,0	0,0	53 529,5				971 134,7
3	Áàýí ä è	833 324,3	311 659,8		198 698,7	0,0	0,0	57 494,5			36 259,4	1 437 436,7
4	Äð°°	984 434,1	401 279,9		378 538,4	0,0	0,0	121 682,8			20 606,8	1 906 542,0
5	Æàãðèàí ò	292 793,1	191 702,5		148 761,4	0,0	0,0	66 974,3				700 231,3
6	Ç¿¿í á¿ðýí	450 436,7	186 771,2		167 125,6	0,0	0,0	60 951,6				865 285,1
7	Ì àí ààè	4 105 180,8	1 369 160,6	112 050,0	339 601,0	209 282,1	78 915,1	131 206,1	386 400,4		132 777,6	6 864 573,7
8	Î ðõí í	310 103,5	145 941,7		168 807,1	0,0	0,0	61 712,1				686 564,4
9	Î ðõí í òóóè	746 057,0	199 325,9		292 299,6	0,0	0,0	105 930,3				1 343 612,8
10	Ñàí ò	337 457,4	160 667,4		164 095,9	0,0	0,0	55 577,4				717 798,1
11	Ñàéðàí	1 576 754,3	1 214 250,6		161 189,0	0,0	0,0	56 021,6		291 267,0	25 868,9	3 325 351,4
12	Ŋ¿ðàààòàð	4 096 547,3	1 947 299,7		0,0	252 842,1	0,0	0,0				6 296 689,1
13	Œø èã	366 536,3	197 341,5		170 079,5	0,0	0,0	61 858,7				795 816,0
14	Хүдэр	485 857,7	217 885,9		165 741,8	0,0	0,0	51 308,7				920 794,1
15	Õóø ààò	279 018,5	139 599,4		144 259,5	0,0	0,0	67 468,2				630 345,6
16	Öàãàí í óóð	728 236,9	284 431,6		187 917,9	0,0	0,0	51 264,5			94 305,2	1 346 156,1
17	Øààí àð	679 596,4	428 328,6		312 028,5	0,0	0,0	102 266,6				1 522 220,1
	сумдын төсөв	17 423 405,2	8 124 256,7	112 050,0	3 348 896,9	462 124,2	78 915,1	1 160 454,7	386 400,4	291 267,0	309 817,9	31 697 588,1
1	Орон нутгийн музей											153 555,0
2	Аймгийн чуулга								538 319,3			538 319,3
3	Аймгийн спорт хороо										343 555,5	343 555,5
4	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар											207 286,0
5	Аймгийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс			177 327,7								177 327,7
6	Боловсрол соёлын газарт сургууль цэцэрлэгийн багш ажиллагсад олгох тэтгэмж	1 473 616,5	488 307,2				0,0					1 961 923,7
7	Аймгийн төв номын сан						168 088,3					168 088,3
	Аймгийн төсөв	1 473 616,5	488 307,2	177 327,7	0,0	0,0	168 088,3	0,0	538 319,3	0,0	343 555,5	3 550 055,5
	Нийт төсөв	18 897021,7	8 612 563,9	289 377,7	3 348 896,9	462 124,2	247 003,4	1 160 454,7	924 719,7	291 267,0	653 373,4	35 247 643,6

-----000-----

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН ЭРХ ЗАХИРАГЧ НАРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН**

Д/д	Төсвийн эрх захирагчийн нэр, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр		Хүрэх үр дүн		Зарцуулах төсөв /сая төгрөг/
			чанар	тоо	
1.	Иргэдийн хурлын дарга				
	1.1.	Үндсэн үйл ажиллагаа			209,7
	1.2.	МУ-ын Засаг захиргаа нутаг дэвсгэр нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан ИТХ-ын чиг үүргийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх		8	
	1.3.	Цагаатгалын ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын шийдвэр, холбогдох хууль журамд заасны дагуу хэлмэгдэгсдийн ар гэр, үр хүүхдэд нөхөн олговор олгох, ажлыг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж хяналт тавих	100%	5	3,0
	1.4.	Малын хулгай, гэмт хэргийн зөрчлийг илрүүлэхэд цагдаа, мэргэжлийн хяналт, тагнуул, прокурортой хамтарсан хяналт шалгалт хийх	100%	14	30,0
	1.5.	Дотоод ажлыг сайжруулахад чиглэгдсэн сургалт зохион байгуулах	100%	7	
2.	Аймгийн ерөнхий аудитор				
	2.1.	Санхүүгийн тайлангийн аудит	сайн	175	157,6
	2.2.	Гүйцэтгэлийн аудит	сайн	14	13,5
	2.3.	Аймгийн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлж зарлага бууруулах санал өгөх	сайн	1	
3.	Засаг дарга				
3.1.	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				
3.1.1	Аймгийн засаг дарга				
	3.1.1.1	Үндсэн үйл ажиллагаа			1 237,7
	3.1.1.2	Сүхбаатар сумын гэрэлтүүлэг			76,6
	3.1.1.3.	Нийтийн тээвэр			35,4
	3.1.1.4.	Аймгийн засаг даргын нөөц			215,3
3.1.2	Орон нутгийн өмчийн алба				
	3.1.2.1	Үндсэн үйл ажиллагаа			45,1
	3.1.2.2	Өмчийн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа			
3.1.3	Худалдан авах ажиллагаа				

	3.1.3.1	Үндсэн үйл ажиллагаа				44,3
	3.1.3.2	Өмчийн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа				
3.1.4	Байгаль орчиныг хамгаалах газар					
	3.1.4.1	Үндсэн үйл ажиллагаа				129,2
	3.1.4.2	Ойжуулалт хийх /га талбайгаар/		сайн	800	160,0
	3.1.4.3	Өмнөх жилийн ойжуулсан талбайд арчилгаа, хамгаалалт хийх /га талбайгаар/		сайн	1180	94,4
	3.1.4.4	Ойн зурвас байгуулах /га талбайгаар/		сайн	10	11,0
	3.1.4.5	Мод үржүүлгийн газар байгуулах, өргөтгөх / 3 газар байгуулах/		сайн	3	30,0
	3.1.4.6	Үрийн талбай тусгаарлах /га талбайгаар/		сайн	5	2,5
	3.1.4.7	Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх	Эргүүл, харуул, сургалт		1	2,5
			Түймрийн тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ /зурвас татах км-ээр/	сайн	50	20,0
	3.1.4.8	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх /га талбайгаар/		сайн	8800	88,0
	3.1.4.9	Ойд арчилгаа цэвэрлэгээ хийх	Сургалт	сайн	1	1,3
			Ойд арчилгаа хийх /насны 2-р ангид тохируулах/ /га талбайгаар/	сайн	50	2,6
	3.1.4.10	Ойн нөхөрлөлийг дэмжих				100,0
	3.1.4.11	Ойн нөхөрлөлүүдийн ойн санд зохион байгуулалт хийх зардал / га талбайгаар/		сайн	30000	3,0
	3.1.4.12	Булаг шандны эхийг хамгаалах / булгийн тоогоор/		сайн	2	4,0
	3.1.4.13	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, аудитын эрх зүйн орчны шинэчлэлийн талаарх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах		сайн	1	6,0
	3.1.4.14	Загасны нөөц тогтоон хамгаалах, зохистой ашиглах төлөвлөгөө боловсруулах		сайн	1	15,0
	3.1.4.15	Байгаль орчин, цаг уур, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, байцаагч, байгаль хамгаалагчдад ургамлын нөөцийг тогтоох, хамгаалах, туршилт судалгаа хийх чиглэлээр сургалт зохион байгуулах		сайн	1	5,0
	3.1.4.16	/Компактор/ хог тээвэрлэх машин 15 м кубын хүчин чадалтай /Мандал/		сайн	1	23,0
	3.1.4.17	/Компактор/ хог тээвэрлэх машин 8 м куб Баянгол, Сайхан, Алтанбулаг сумд/хилийн чөлөөт бүстэй, хил		сайн	8	96,0
	3.1.4.18	Аймгийн төв Сүхбаатар сумын төвлөрсөн хогын цэгт, хог хаягдалыг ангилан ялгах цех байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх		сайн	1	101,1
	3.1.4.19	Мандал суманд Ландфиллын аргаар хог хаягдал дарж булах цэг байгуулах		сайн	1	168,0

	3.1.4.20	ХАА-н салбарт хэрэглэгдэж байгаа химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг хүлээн авах агуулах аймгийн төвд байгуулж, цуглуулах арга хэмжээ авах	сайн	1	350,0
	3.1.4.21	Хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах, ангилан ялгах сургалт зохион байгуулах /бүх сумдад/	сайн	17	8,5
	3.1.4.22	ArcGIS 10.0.1 програм хангамж худалдан авах, програм хангамжийн сургалтад хамрагдах	сайн	1	11,8
	3.1.4.23	Ерөө, Хүдэр суманд улсын үйлдвэрийн газар ашиглаж байгаад орхигдсон газарт мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлт хийлгэх /га талбайгаар/	сайн	100	600,0
	3.1.4.24	Хууль бусаар ашигт малтмал олборлосны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг тооцох /10 суманд/	сайн	10	2,0
	3.1.4.25	Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг хөгжүүлэх /Тужийн нарс Улсын тусгай хамгаалалтын газар/	сайн	2	3,4
	3.1.4.26	Уур амьсгалын өөрчлөлтийн хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	сайн	1	3,0
3.1.5	Ахмадын хороо				
	3.1.5.1	Үндсэн үйл ажиллагаа			13,2
3.1.6	Халамжийн хэлтэс				
	3.1.6.1	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	Бүрэн хамруулна		42,2
	3.1.6.2	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээнийхураамж	Бүрэн хамруулна		9,1
	3.1.6.3	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ /жилд нэг удаа үйлчилгээ үзүүлэх/	Бүрэн хамруулна	400	89,0
	3.1.6.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ	Бүрэн хамруулна	52	367,8
	3.1.6.5	Ахмад настуудад хөнгөлөлт үзүүлэх	Бүрэн хамруулна	183	478,7
	3.1.6.6	Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг үзүүлэх	Бүрэн хамруулна	9800	588,3
		Зарцуулах төсөв			1 575,1
3.1.7	Мал эмнэлгийн үйлчилгээ				
	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ				
	3.1.7.1	Боомоос сэргийлэх	Бүрэн хамруулна	580	269,0
	3.1.7.2	ДХХ-оос сэргийлэх	Бүрэн хамруулна	180	162,0
	3.1.7.3	Дуутаас сэргийлэх	Бүрэн хамруулна	60	30,0
	3.1.7.4	Цусан халдвараас сэргийлэх	Бүрэн	63	627,0

			хамруулна		
	3.1.7.5	Галзуугаас сэргийлэх	Бүрэн хамруулна	18	9,0
	3.1.7.6	Сохор доголоос сэргийлэх	Бүрэн хамруулна	180	81,0
	3.1.7.7	Шөвөг яраас сэргийлэх үйлчилгээ	Бүрэн хамруулна	360	162,0
	3.1.7.8	Сахуу	Бүрэн хамруулна	28	14,0
	3.1.7.9	Ц/ХИБ-аас сэргийлэх	Бүрэн хамруулна	12	12,0
	3.1.7.10	Мялзангаас сэргийлэх	Бүрэн хамруулна	12	6,0
	3.1.7.11	Ёломоос сэргийлэх	Бүрэн хамруулна	12	6,0
	3.1.7.12	Боом ийлдэс	Бүрэн хамруулна	2	1,0
	3.1.7.13	ДХХ ийлдэс	Бүрэн хамруулна	1,8	1,0
	3.1.7.14	Цусан халдвар ийлдэс	Бүрэн хамруулна	14	1,0
	3.1.7.15	Колибактериоз	Бүрэн хамруулна	15	1,0
	Лабораторын шинжилгээнд хамрагдах мал, амьтны тоо, үйлчилгээний хөлс				
	3.1.7.16	Бруцеллёзын шинжилгээ		7	1,7
	3.1.7.17	Сүрьеэгийн сорил	Бүрэн хамруулна		
	3.1.7.18	Ямын сорил	Бүрэн хамруулна		
	3.1.7.19	АХЦБӨ-ний шинжилгээ	Бүрэн хамруулна	48	
		Зарцуулах төсөв	Бүрэн хамруулна		547,7
3.2.	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				
3.2.1	Ерөнхий боловсрол				
	3.2.1.1	Аааа, пöööü, áçäýí äóí ä äí ëí âñðí èü í ñààí ääðð, ñóðäæöü í ò° è° äæ° ä° , ò° ò° èá° ðæäüðýäæçýýð сургуулийн тоо		35	16,4
	3.2.1.2	Үдийн цай хөтөлбөрт хамрагдаж буй хүүхдийн тоо	Бүрэн хамруулна	8578	0,8
	3.2.1.3	Äð° í ðæé äí ëí âñðí èü í ñóðäæöüü Äí ðóóð ääæðí ü хэвийн үйл ажиллагааг хангах үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо	Бүрэн хамруулна	1230	1,4

	3.2.1.4	Äçëðñýí ð°ð°éá°ð°°ð àëääí áóñ áí èí añðí è î ëä ð үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо	Бүрэн хамруулна	559	126,6
	3.2.1.5	Ерөнхий боловсролын сургууль орой, эчнээ сургалтын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо	Бүрэн хамруулна	97	1,6
	3.2.1.6	Сургуулийн өмнөх боловсрол хамрагдаж буй хүүхдийн тоо	Бүрэн хамруулна	7297	8 612,5
	3.2.1.7	Бага насны хүүхдийг асран хамгаалах, хөгжүүлэхэд хамрагдаж буй хүүхдийн тоо	Бүрэн хамруулна	5763	7 952,0
	3.2.1.8	24 цагийн ажиллагаатай цэцэрлэгийн үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо	Бүрэн хамруулна	188	320,3
	3.2.1.9	СӨБ-ын хувилбарт сургалтын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо	Бүрэн хамруулна	1346	339,1
		Зарцуулах төсөв			18 897,0
3.2.2	Эрүл мэнд				
	3.2.2.1	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл		7	
	3.2.2.2	1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		4	
	3.2.2.3	Шүд цоорлын тархалт нийт хүн амд эзлэх хувь		17	
	3.2.2.4	Эмнэлгийн үндсэн оношын зөрүүний хувь		0	
	3.2.2.5	Эмнэлгийн хоног болоогүй нас баралт		27	
	3.2.2.6	Амбулаторийн нийт үзэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	Бүрэн хамруулна	39	
	3.2.2.7	Жирэмсний хяналтад байх хугацаандаа 6 буюу түүнээс дээш үзүүлсэн жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь		85	
	3.2.2.8	Жирэмсний эрт үеийн хяналтын хувь		81	
	3.2.2.9	Мэс заслын дараах хүндрэлийн хувь		0	
		Зарцуулах төсөв			3 348,8
3.2.3	Биеийн тамир, спорт хороо, клуб				
	3.2.3.1	Нийтийн биеийн тамираар хичээллэгчид /нийт хүн амд эзлэх хувиар/	Бүрэн хамруулна	23	
	3.2.3.2	Улсын аварга		386	
	3.2.3.3	Тивийн аварга		4	
	3.2.3.4	Дэлхийн аварга		2	
		Зарцуулах төсөв			653,3
3.2.4	Газрын харилцаа, геодези, зурагзүйн газар				
	3.2.4.1	Засгийн газраас хэрэгжүүлж байгаа барилга хот байгуулалтын хөтөлбөр төслүүдийн хэрэгжүүлэлтийг хангуулах		4	
	3.2.4.2	Барилгын талаархи төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион		6	

		байгуулах			
	3.2.4.3	Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга, засвар шинэчлэлтийн ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавих /бүх сумдад/		17	
	3.2.4.4	Иргэн Аж ахуйн нэгж байгууллагын кадастрын зураглал хийж, улсын бүртгэлд бүртгэж мэдээллийн санг баяжуулах		3	
	3.2.4.5	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх		6	
	3.2.4.6	Газрын төлбөр ноогдуулах, төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах		2	
	3.2.4.7	Улс, аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий газар төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэх		1	
		Зарцуулах төсөв			207,2
3.2.5	Орон нутгийн хүүхдийн байгууллага				
	3.2.5.1	<i>Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги /2012-2015 он/</i> Аймаг, сумын Засаг дарг, хүүхдийн төлөө зөвлөлийн дарга нарт зориулсан хүүхдийн эрх, хамгааллын эрх зүйн сургалтыг зохион байгуулах		1	
	3.2.5.2	Сум бүрт ажиллаж байгаа хүүхдийн элч нарт олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх		17 элч	
	3.2.5.3	Цагдаагийн байгууллагад "Хүүхдээс мэдүүлэг авах танхим"-ыг бий болгох		1	
	3.2.5.4	Хүүхэд хамгаалал болон хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар эцэг эх, олон нийтийн мэдлэг, дадал, зан үйлийг өөрчлөх сургалтууд зохион байгуулах жилдээ		4	
	3.2.5.5	"Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах" олон нийтийн санал санаачлагыг өрнүүлэх: Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын сургалтийг хүүхдийн хөгжил оролцооны байгууллага, зуслангийн хөгжлийн хөтөлбөрөөр осол, гэмтэл, гамшгийн мэдлэг олгох сургалт зохион байгуулах			
	3.2.5.6	Гэр бүлийн өдрийг тохиолдуулан шилдэг гэр бүл шалгаруулах, эцэг эхийн зөвлөгөөн зохион байгуулах			
		Зарцуулах төсөв			289,3

_____оОо_____

**2013 ОНЫ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/сая.төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2013 онд санхүүжүүлэх дүн
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			3 390,40	3390,40
1	Засаг дарга		3 390,40	3 390,40
1.1.	Хөрөнгө оруулалт		2 529,25	2 529,25
<i>Шилжих хөрөнгө оруулалт</i>			334,25	334,25
1.1.1	Шаамар сумын Дулаанхан тосгоны хүн эмнэлгийн барилгын үлдэгдэл санхүүжилт	2013	95,00	95,00
1.1.2	Сүхбаатар сумын 5-р багт баригдаж буй соёлын төв ахуйн үйлчилгээний барилгыг гүйцээх	2013	239,25	239,25
<i>Шинээр эхлэх хөрөнгө оруулалт</i>			2 195,00	2 195,00
1.1.3	Алтанбулаг сумын 1 км хатуу хучилттай авто зам	2013	140,00	140,00
1.1.4	Ерөө сумын Бугант тосгонд хүүхдийн цэцэрлэг барих	2013	150,00	150,00
1.1.5	Зүүнбүрэн сумын цагдаагийн кабоны барилга	2013	65,00	65,00
1.1.6	Зүүнбүрэн суманд цэнгэлдэх хүрээлэн барих	2013	60,00	60,00
1.1.7	Мандал суманд авто зам тавих	2013	500,00	500,00
1.1.8	Орхон сумамд бэлчээрийн гүний худаг гаргах	2013	30,00	30,00
1.1.9	Сайхан сумын Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээ	2013	240,00	240,00
1.1.10	Орхонтуул суманд Wi Fi интернэтийн орчин бий болгох	2013	30,00	30,00
1.1.11	Баруунбүрэн суманд байрлах Амарбаясгалант хийдэд нийтийн ариун цэврийн өрөө барих	2013	65,00	65,00

1.1.12	Хүдэр суманд Wi Fi интернэтийн орчин бий болгох	2013	30,00	30,00
1.1.13	Сүхбаатар сумын гэр хороололд дулааны болон цэвэр усны шугам тавих	2013	680,00	680,00
1.1.14	Жавхлант сумын эмнэлгийн барилгын өргөтгөл	2013	50,00	50,00
1.1.15	Жавхлант сумын баруун хороололд гүний худаг гаргах	2013	25,00	25,00
1.1.16	Жавхлант суманд ахмадын өргөө барих	2013	30,00	30,00
1.1.17	Түшиг сумын ЗДТГ-ын урд цэцэрлэгт хүрээлэн тохижуулах	2013	40,00	40,00
1.1.18	Хушаат сумын Дуулга хороололд цахилгааны шугам барих	2013	30,00	30,00
1.1.19	УЦУОША-нд үүлэнд зориудаар нөлөөлж хур тундас нэмэгдүүлэх	2013	30,00	30,00
1.2	Тоног төхөөрөмж		123,55	123,55
1.2.1	Орхон сумын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж, хэрэгсэл	2013	23,55	23,55
1.2.2	Шаамар сумын сургуулийн ширээ сандал	2013	20,00	20,00
1.2.3	Шаамар сумын Дулаанхан тосгоны соёлын төвд хөгжим хэрэгсэл авах	2013	5,00	5,00
1.2.4	БТСГазарт боксын ринг авах	2013	15,00	15,00
1.2.5	Хөдөлмөрийн хэлтэст авто машин авах	2013	30,00	30,00
1.2.6	Орон нутгийн өмчийн албанд авто машин авах	2013	30,00	30,00
1.3	Их засвар		737,60	737,60
1.3.1	Ерөө сумын эмнэлгийн цэвэр, бохир усны шугам засвар	2013	40,00	40,00
1.3.2	ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ 42-р зөрлөгийн хайрган авто зам сайжруулах	2013	60,00	60,00
1.3.3	Сант сумын Засаг даргын Тамгын газрын тавилга хэрэгсэл, барилгын засвар, дээвэр засвар	2013	60,00	60,00
1.3.4	Сант сумын багийн байрны засвар	2013	30,00	30,00
1.3.5	Цагааннуур сумын цэцэрлэгийн	2013	150,00	

	сантехник, цахилгаан, барилгын засвар			150,00
1.3.6	Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засвар, тавилга хэрэгсэл	2013	35,00	35,00
1.3.7	Баянгол сумын сургуулийн ариун цэврийн өрөөний засвар	2013	30,00	30,00
1.3.8	Баянгол сумын төвийн инженерийн шугам засвар	2013	30,00	30,00
1.3.9	Сайхан сумын 20-р цэцэрлэгийн сантехник засвар	2013	30,00	30,00
1.3.10	Орхонтуул сумын халаалтын тогоо байрлуулах	2013	40,00	40,00
1.3.11	Баруунбурэн сумын дулааны шугам засвар	2013	45,00	45,00
1.3.12	Хүдэр сумын цэцэрлэгийн бохир усны гадна шугам засвар	2013	42,00	42,00
1.3.13	Хүдэр сумын эмнэлгийн гадна шугам засвар	2013	17,00	17,00
1.3.14	Түшиг сумын сургуулийн сантехник, ариун цэврийн өрөөний засвар	2013	50,00	50,00
1.3.15	Хушаат сумын хүн эмнэлгийн сантехник засвар, эргэлтийн эмийн сан, стандартын моорог, гараж барих	2013	40,00	40,00
1.3.16	Хушаат сумын сургуулийн цахилгааны засвар	2013	38,60	38,60
СУМ, ДҮҮРГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ			5 085,60	5 085,60
	НИЙТ ДҮН		8 476,00	8 476,00

оОо

**2013 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/сая. төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2013 онд санхүүжүүлэх дүн
ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			330,75	330,75
1	Засаг дарга		330,75	330,75
1.1.	Их засвар		330,75	330,75
1.1.1	Алтанбулаг сумын зам засвар	2013	16,5	16,5
1.1.2	Ерөө сумын зам засвар	2013	16,5	16,5
1.1.3	Зүүнбүрэн сумын зам засвар	2013	9,9	9,9
1.1.4	Мандал сумын зам засвар	2013	82,5	82,5
1.1.5	Орхон сумын зам засвар	2013	6,6	6,6
1.1.6	Сант сумын зам засвар	2013	6,6	6,6
1.1.7	Цагааннуур сумын зам засвар	2013	16,5	16,5
1.1.8	Баянгол сумын зам засвар	2013	16,5	16,5
1.1.9	Сайхан сумын зам засвар	2013	19,8	19,8
1.1.10	Орхонтуул сумын зам засвар	2013	13,2	13,2
1.1.11	Баруунбүрэн сумын зам засвар	2013	9,9	9,9
1.1.12	Шаамар сумын зам засвар	2013	13,2	13,2
1.1.13	Хүдэр сумын зам засвар	2013	6,6	6,6
1.1.14	Сүхбаатар сумын зам засвар	2013	76,65	76,65
1.1.15	Жавхлант сумын зам засвар	2013	6,6	6,6
1.1.16	Түшиг сумын зам засвар	2013	6,6	6,6
1.1.17	Хушаат сумын зам засвар	2013	6,6	6,6
НИЙТ ДҮН			330,75	330,75

оОо

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 04-ний өдөр

Дугаар 09

Сүхбаатар

**Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээг
шинэчлэн тогтоох тухай**

Монгол Улсын Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны А-415 тоот тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг 1 дүгээр хавсралтаар, рашаан ашигласны төлбөрийн хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоолыг мөрдүүлэх, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч биелэлтэнд байнгын хяналт тавьж, хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2005 оны 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, 2011 оны 62 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 63 дугаар тогтоолын 2 дахь заалтаас бусад заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

БАЙГАЛИЙН УРГАМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Байгалийн ашигт зарим ургамлын нэрс		Хэмжиг нэгж /кг/	Төлбөрийн хэмжээ /төгрөг/	
	Монгол	Латин		Иргэн	Аж ахуйн нэгж, байгууллага
Ховор ургамал					
1	Эмийн бамбай	Valeriana officinalis Lebeb.	кг	1800	2400
2	Цагаан Дэгд	Geniana acuta Michx		1500	2000
3	Зузаан навчит (пагдагар) Бадаан	Bergenia crassifolia (L.) Fritsch		2250	3000
4	Илдэн Игүүшин	Cacalia hastate L.		1425	1900
2.5	Хүн ам, орон сууцны завсарын тооллогыг явуулах	2015	Статистикийн хэлтэс Аймгийн Засаг дарга	2015 онд хүн ам зүйд орсон өөрчлөлтийг харуулна.
2.6	Тооллого судалгааны үр дүнгээр хэрэглэгчид зориулсан гарын авлага, сурталчилгааны материал бэлтгэх	2012-2015	Статистикийн хэлтэс Аймгийн ЗДТГ	Хэрэглэгч тооллогын судалгааны үр дүнгийн мэдээлэлтэй болно.
Гурав.Салбарын статистикийг боловсронгуй болгох Хүрэх үр дүн: Багийн түвшинд хүн ам ,өрхийн дэлгэрэнгүй мэдээллийн санг баяжуулж, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагай мэдээлэл солилцох боломж нэмэгдэнэ.				
3.1	Хөдөө аж ахуйн салбарт өрхөд суурилсан бүртгэлийн системийг бий болгох, мэдээллийн санг бүрдүүлэх	2013	Статистикийн хэлтэс Аймгийн ХХААЖДҮГ	Аймгийн хэмжээний ХАА эрхэлдэг өрхийн мэдээллийн сантай болно.

1	2	3	4	5
3.2	Хүн ам, өрхийн мэдээллийн санг шинэчилсэн үзүүлэлтээр баяжуулах, албан ёсны статистикийн мэдээлэл гаргахад өргөн ашиглах	2012-2015	Статистикийн хэлтэс Аймгийн Засаг дарга Сумдын Засаг дарга нар	Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийг албан ёсны мэдээлэл гаргахад өргөн ашиглана.
3.3	Өрх, хүн амын мэдээллийн санг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүртгэлтэй уялдуулах, шаардлагатай мэдээллийг солилцох	2013-2015	Статистикийн хэлтэс Улсын бүртгэлийн хэлтэс	Бүртгэлийн бусад байгууллагатай мэдээлэл солилцох нөхцөл бүрдэнэ.
3.4	Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн баяжилтийг тогтмол хийж түүвэр судалгаанд хамрагдах өрхийн жагсаалт, хүн ам зүйн нарийвчилсан мэдээллийг гаргахад ашиглах	2012-2015	Статистикийн хэлтэс Сумдын багийн Засаг дарга, статистикийн ажил хариуцсан ажилтан	Хүн ам, өрхтэй холбоотой судалгаанд мэдээллийг ашиглана.
3.5	Хөдөө аж ахуйн тооллого явуулах	2012	Статистикийн хэлтэс Аймгийн ХХААЖДҮГ	ХААН салбарын үйлдвэрлэл эрхэлдэг өрх бүрийн мэдээллийн сантай болно.
3.6	Хувийн орон сууцны гүйцэтгэл, хувиараа барилга угсралт, их засварын ажил хийж байгаа иргэдийн талаар түүвэр судалгаа явуулах	2013	Статистикийн хэлтэс Сумдын ЗДТГ	Хувиараа барилгын салбарт ажиллагсадын талаар мэдээлэлтэй болно.
3.7	Хот хоорондын болон сум доторхи зорчигч тээвэрлэлт, ачаа тээвэрлэлтийн талаар түүвэр судалгаа явуулах	2013	Статистикийн хэлтэс Сумдын ЗДТГ	Зорчигч тээвэр, ачаа тээвэрлэлтийн талаар мэдээлэлтэй болно.

1	2	3	4	5
3.8	Сумдын дотоодын нийт бүтээгдэхүүний тооцооны хамралтын хүрээг нэмэгдүүлэх	2013	Статистикийн хэлтэс, сумдын статистик мэдээлэл хариуцсан ажилтан	Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо хамралт мэдээллийн чанар сайжирна.
3.9	Үнийн статистикийн мэдээллийн хамрах хүрээг нэмэгдүүлэх	2013-2015	Статистикийн хэлтэс	Үнийн индексийн тооцоо сайжирна.
<u>Дөрөв.Мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх</u> Хүрэх үр дүн: Техник технологийн шинэчлэл хийж сум багийн түвшинд техник технологийн хүчин чадал сайжирна.				
4.1	Анхан шатны мэдээлэл цуглуулах болон мэдээллийн тархаалтанд орчин үеийн зөөврийн тоног төхөөрөмж ашиглах	2012-2015	Статистикийн хэлтэс Сумдын ЗДТГ	Мэдээллийг цаг тухай бүрт нь шуурхай дамжуулна.
4.2	Статистикийн хэлтсийн болон статистик мэдээлэл хариуцсан ажилтнуудын техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг байнга шинэчлэх	2013-2015	Статистикийн хэлтэс Аймгийн Засаг дарга Сумдын Засаг дарга нар	Сум, багийн түвшинд техник тоног төхөөрөмжийн ашиглалт нэмэгдэнэ.
4.3	Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, хамгаалалтын стандартыг мөрдөж ажиллах	2012-2015	Статистикийн хэлтэс, сумдын статистик мэдээлэл хариуцсан ажилтнууд	Мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг өндөр түвшинд хүргэнэ.
<u>Тав.Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх</u> Хүрэх үр дүн: Статистикийн ажилтны ажлын бүтээмж нэмэгдэж, бүтээгдэхүүний чанар сайжран, хэрэглэгчийг үнэн бодитой, чанартай мэдээллээр хангана.				
5.1	Ажлын байранд сэлгэн ажиллуулах үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, хөрвөн ажиллах чадварыг дээшлүүлэх	2013-2015	Статистикийн хэлтэс	Ажилтнууд хэн нэгнийгээ орлон ажиллах чадвартай болно.

1	2	3	4	5
5.2	Тодорхой бодлого чиглэлээр ажилтныг мэргэшүүлэх, дадлагажуулах	2013-2015	Статистикийн хэлтэс Сумдын ЗДТГ	Мэргэшсэн чадварлаг боловсон хүчний нөөцтэй болно.
5.3	Байгууллагын дотоод зохион байгуулалт, ажиллах орчин нөхцлийг сайжруулах	2012-2015	Статистикийн хэлтэс Сумдын ЗДТГ	Ажиллах орчин нөхцөл сайжирснаар үр бүтээлтэй ажиллана.

_____oOo_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2012 оны 11 сарын 27-ны өдөр

Дугаар 119

Сүхбаатар

Анхдугаар хуралдаан зарлах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.2012 оны сонгуулиар шинээр сонгогдсон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдөр аймгийн төвд хуралдуулж доорхи асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:

1.Аймгийн ИТХ-ын шинээр сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

2.Анхдугаар хуралдааны дэгийн төсөл

3.Хурлын зохион байгуулалтын асуудал

-Аймгийн ИТХ-ын даргыг сонгох тухай

-Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг сонгох тухай

-Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай

-Аймгийн ИТХ-ын бодлогын хороог байгуулах тухай

-Аймгийн ИТХ-ын хорооны даргыг сонгох тухай

Хоёр. Хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /О.Буянтогтох/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 03-ны өдөр

Дугаар 122

Сүхбаатар

Хуралдаан зарлах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2 дэх хэсгийн заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдааныг 2012 оны 12 дугаар сарын 04-ний өдөр аймгийн төвд хуралдуулж доорхи асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:

1.Аймгийн 2013 оны төсвийн төсөл

Хоёр. Хуралдаанд оруулах асуудлыг хуралдааны дэгт заасан шаардлагын түвшинд боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 124

Сүхбаатар

Аймгийн Аудитын газрын тайлангийн тухай

Аймгийн Аудитын газрын 2012 оны ажлын тайланг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн Аудитын газраас 2012 онд хийсэн ажлыг “Хангалттай сайн” гэж дүгнэсүгэй.

2.2013 онд төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажлыг сайжруулах, хийж гүйцэтгэж буй аудитын үр өгөөжийг дээшлүүлэх, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн барагдуулж арилгах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулахыг аймгийн ерөнхий аудитор /Ч.Насанбат/-т даалгасугай.

3.2012 онд үр бүтээлтэй сайн ажилласан ерөнхий аудитор Ч.Насанбатыг нэг сарын үндсэн цалингаар шагнаж, шагналын мөнгийг тус газрын цалингийн сангаас тооцон гаргахыг зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 125

Сүхбаатар

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Хүнсний ногоо" аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулж биелэлтийн явцыг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

“ ХҮНСНИЙ НОГОО ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Хүнсний ногооны хэрэглээ, өнөөгийн байдал

Монгол Улсын Их хурал, Засгийн газраас хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг хангах чиглэлээр үндэсний хөтөлбөрүүд батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал: “Атрын III дахь аян”, “Хүнсний аюулгүй байдал”, “Ногоон хувьсгал” зэрэг үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 16.0 мянган тн бордоо, хүлэмж 150, дуслын болон энгийн усалгааны тоног төхөөрөмж болон бусад тоног төхөөрөмж хүлэмжийн нийлэг хальс төрөл бүрийн хүнсний ногооны үр 1500 кг зэргийг дэмжлэг болгон олгосон.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2005 онд өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор сум бүрд төмс, хүнсний ногооны зориулалттай 5ш бага оврын трактор олгож, мөн 2008 онд сум бүрд “Агропарк” байгуулах Засгийн газрын тогтоолын дагуу 127.5 сая төгрөгийн гэрээ хийж агропарк байгуулж жижиг оврын трактор, Солонгос хүлэмж, 600 тн-ын багтаамжтай 17 зоорь барьж ашиглалтанд оруулсан.


Сүхбаатар Цагааннуур, Сайхан, Алтанбулаг, Мандал сумдад нийлбэр дүнгээрээ 528 тн хүнсний ногоо боловсруулах хүчин чадалтай цехүүд ашиглалтанд орсноор хүнсний ногоог үйлдвэрийн аргаар боловсруулах боломж нэмэгдэж байна.

Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор сүүлийн 4 жил үр үржүүлэх, үр шинэчлэхэд аймаг хөгжүүлэх сангаас 400-600 сая төгрөгийн зээлийг төмс, хүнсний ногоо тариалагчдад 7 сарын хугацаатай хүүгүй олгосон нь тэдэнд ихээхэн дэмжлэг болж байгаа юм.

Үйлдвэр хөдөө аж ахуйн яамтай хамтарч 2001 оноос “Алтан намар” 2004 оноос хойш “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг уламжлал болгон жил

бүр зохион байгуулж мөн Улаанбаатар хотын томоохон худалдааны төв, дүүргүүдэд “Сэлэнгийн ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж бүх сумдын ногоочдыг оролцуулж төмс хүнсний ногоогоо борлуулалахад нь дэмжлэг үзүүлж байна.

“Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагатай хамтран төмсний үр үржүүлэх зорилгоор 600 тн төмсний элит үрийг 17 сумын иргэдэд олгосны үр дүнд энэ жилийн төмсний тариалалт эрс нэмэгдэж төмс 3330.8 га, хүнсний ногоо 2045.0 га, тариалсан нь өмнөх оныхоос төмс 14.5 хувь, хүнсний ногоо 12.3 хувиар өссөн.



2012 оны байдлаар байцаа 405 га, лууван 643 га, манжин 330 га, өргөст хэмх 121 га, улаанлооль 61 га, тарвас 144 га, сонгино 217 га, сармис 37 га, бусад ногоо /чинжүү, цэс, хулуу, улаан лууван, салатны байцаа, цэцэгт байцаа, гоньд, брокколи, тагар сонгино, хүнсний шош, вандуй, цоохор майлз, бууцай/ 86 га талбайд тариалж байна.

Судалгаанаас харахад хүнсний ногооны тариалах талбай болон ургац нь нэмэгдэж байгаа боловч таримлын нэр төрөл нэмэгдээгүй, ихэнх талбайг уламжлал болсон цөөн төрлийн ногоо эзэлж байна.


Хүнсний ногооны бүтээгдэхүүнийг агуулах зоорийг сэргээн засварлах, шинээр барих зэрэгт дэмжлэг үзүүлж, өнөөдөр аймгийн хэмжээнд 3033 зооринд, 28950 тн-ийн хүнсний ногоо хадгалах боломжтой болоод байна.

Сүүлийн 5 жилд ургац дундажаар төмс 46064 тн, хүнсний ногоо 36125 тн, нийт 82189 тн ургац хураан авч ургац хураалтын дараа буюу 9,10,11 дүгээр сард нийт ургацынхаа 49314 тн буюу 60 хувь, 12,1,2 саруудад 20547 тн буюу 25 хувь, 3,4,5 дугаар саруудад 8219 тн буюу 10 хувийг борлуулж, 4109 тн буюу 5 хувийг нь өөрсдийн хэрэгцээнд хэрэглэсэн гэсэн бүрэн бус мэдээлэл байна. Нийт ургацын борлуулалтыг мөнгөн дүнгээр үзэхэд 20.0 орчим тэрбум төгрөгийн борлуулалт хийдэг бөгөөд нэг ногоочин бүтэн жилийн турш хөдөлмөрлөж дунджаар 4.8 сая төгрөгийн борлуулалт хийсэнхарагдаж байгаа нь өрхийн ашиг төдийлөн өндөр биш үзүүлэлт юм.

Мөн хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлэх зорилгоор 2012 онд 71 хүлэмжийг нийлүүлж, нийт 376 хүлэмж үүнээс зуны хүлэмжний 36096 м² талбайгаас 253 тн, өвлийн хүлэмж нь 540 м² талбайгаас 4.86 тн ургац хураан авч байгаа нь нийт хүнсний ногооны хураан авч байгаа ургацын дөнгөж 7.1 хувийг эзлэж байна.

2012 оны байдлаар Сэлэнгэ аймагт төмс хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлж буй нийт 6184 иргэн /үүний дотор 1200 өрх толгойлсон эмэгтэйчүүд/ 28 хоршоо, 125 бүлэг ажиллаж байна.

Ногоочдын насны ангилал, бүлгийн судалгаа



Эдгээр иргэд, аж ахуйн нэгж, бүлгийн тариалж буй талбайг ангилж үзвэл 1 га талбайтай 478, 1-3 га талбайтай 232, 3-5 га талбайтай 104, 5-8 га талбайтай 9, 8-10 га талбайтай 6, 10 дээш га талбайтай 4 аж ахуйн нэгж байдаг нь нийт

үйлдвэрлэл эрхлэгчдийн талбайн 14 хувь, 1-ээс доош га талбайтай иргэд ихэнх нь байдаг бөгөөд нийт талбайн 86 хувийг эзэлж байна.

Энэ нь хүнсний ногоо тариалагчид өөрийн техникгүйгээс хөрс боловсруулахаас бусад ажлыг гараар хийдэг хүнд хүчир ажил ихтэй учир бага талбайг ашиглаж байна.

2012 оны байдлаар үзэхэд 2148 га талбайд хүнсний ногоо тариалж нийт 1115 га талбайг бордсон үүнээс органик бордоогоор 681 га, эрдэс бордоогоор 467 га талбайг бордож, нийт 31880.3 тн буюу нийт тариалах талбайн 51.9 хувийг бордож байна.

Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн чиглэлээр Мандал суманд үйл ажиллагаа эрхэлдэг Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хүнсний ногооны үр үржүүлгийн салбарт бөөрөнхий байцааны эрт, дунд, орой болцтой сортыг 3.6-5 га талбайд тариалж 60-200 кг үр үржүүлдэг.

Мөн иргэд урт, бөөрөнхий сонгино, тагар сонгино, сармисны үр, булцуугаар үржүүлж байгаа ч аймгийн хэмжээний хүнсний ногооны үрийн хэрэгцээг хангаж чадахгүй, импортын үрээр тариалж байна.

Улсын хэрэгцээт төмсийг 100 хувь, хүнсний ногооны 70 хувийг дотоодын ургацаар хангаж, 2008 оныг 2012 онтой харьцуулахад төмсний импорт 4 дахин, хүнсний ногооны импорт 2 дахин буурсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 257 тоот тушаалаар батлагдсан хүн амын хоол тэжээлийн физиологийн норм, аргачлалаар Монгол хүн хоногт 140 грамм төмс, 200 грамм хүнсний ногоо хэрэглэх ёстой. Харин 2005 онд нэг хүнд ногдох төмс, хүнсний ногооны хэмжээ хоногт 80 гр байсан нь хоногт зайлшгүй хэрэглэх шаардлагатай төмс, хүнсний ногооны 30.9 хувийг л хэрэглэж байсан бол 2012 оны байдлаар төмс 146.7 гр, хүнсний ногооны 201.3 гр хэрэглэж, жил бүр 5-10 хувиар хэрэглээ нь өссөн байна.

Манай аймаг төмс, хүнсний ногооны хэрэгцээгээ аймгийн үйлдвэрлэлээр 100 хувь хангаж, үлдсэн хувийг аймаг, нийслэлийн зах зээлд нийлүүлдэг боловч хүнсний ногооныхоо 1,2 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулж байгаагаас үзэхэд

том, дунд, бага оврын үйлдвэр, цехүүдийг байгуулах хэрэгцээ шаардлага байгаа юм.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах шаардлага, үндэслэл

Монгол Улсын Их хурал, Засгийн газраас Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхээр тодорхой бодлогыг чанартай хөтөлбөрүүдийг батлан гарсан.

“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрт хүнсний ногооны талаар тусгагдсан боловч хангалтгүй нөгөөтэйгүүр “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр хэрэгжиж дууссан, хүнсний ногооны үйлдвэрлэл, ногоочдыг дэмжих талаар системтэй цогц арга хэмжээг авах эрхзүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байгаа талаар ногоочид байнга санал тавьж байдаг юм.

Өнөөдөр аймгийн хэмжээнд тариалах талбай нэмэгдэж, төмс 4062 га, хүнсний ногоо 2148 га талбайд тариалж, мөн тэр хэмжээгээр ургац нэмэгдэж, өсөх хандлага гарч байгаа боловч төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн гар ажиллагааг механикжуулах, ногоочдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Манай ногоочидын тариалсан ногоог газар дээр нь ченжүүд 350-500 төгрөгөөр худалдан авч Улаанбаатар хотын томоохон худалдааны төвүүдэд 1000-1500 төгрөгөөр зарж борлуулж байгаа нь ногоочин ченж 2-ын дунд 650-1000 төгрөгийн үнийн зөрүү гарч ногоочдын хөдөлмөр, түүний эдийн засгийн байдалд хохирол учруулж байгааг анхаарах ёстой.

Хүнсний ногооны ач холбогдол, ашиг тусыг хүн бүр мэдэрч Монгол Улсын хүн амын хүнсний хэрэглээний гол бүтээгдэхүүн нь эх орны хөрсөнд ургасан цэвэр экологийн эрүүл хүнсний ногоог түлхүү, өргөн хэрэглэх хандлага гарч байна.

Төр засгаас импортоор орж ирж байгаа ижил төрлийн хүнсний ногоонд гаалийн 15, НӨАТ-ын 10, нийт 25 хувийн татвар бий болгосонч Хятадын чанар муутай үнэ багатай ногоо ихээр орж ирэх боломжийг бүрэн хаагаагүй, эх орны хөрсөнд ургасан ногооны борлуулалтанд муугаар нөлөөлж байна.

Хүнсний ногооны тариалах талбай нэмэгдэж байгаа боловч ихэнх ногоочид тариалалт, ургац хураалтын ажлыг гол төлөв гар ажиллагаагаар хийж, хүнд хүчир

хөдөлмөрт нухлагдаж, цаг наргүй ажиллаж байгаа ч хөдөлмөрийн бүтээмж нь муу байна.

Тийм учраас хүнсний ногооны хөрс боловсруулах, үрлэх, услах, хог ургамалтай тэмцэх, мөр хоорондын боловсруулалт хийх, хор бордоо цацах, ургац хураах ажилд хөдөлмөр хөнгөвчлөх техник, тоног төхөөрөмж зайлшгүй шаардлагатай байна.

Борлуулалтын системийг цогцоор нь авч шийдвэрлэх, хүнсний ногооны нэр төрлийг олшруулж үйлдвэрийн аргаар боловсруулж сав баглаа боодол нэр хаягийг нь тодорхой болгож, зах зээлд борлуулах хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн асуудлыг ч цогцоор нь авч шийдвэрлэх үрийн аж ахуйг байгуулах ногоочдын мэдлэг мэргэжлийг системтэй дээшлүүлж шинэ залуу ногоочдыг сургах ажлыг ч тусгайлан авч үзэх шаардлагатай байна.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Хүнсний ногоо” аймгийн хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай болсон юм.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

- Дотоодын зах зээлийн хэрэгцээг бүрэн хангаж, гадаад зах зээлд нийлүүлэх хэмжээнд экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих.
- Хүнсний ногооны стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан гарал үүсэл, нэр хаяг нь тодорхой бүтээгдэхүүний борлуулалтыг зах зээлд гаргахад нь дэмжлэг үзүүлэх
- Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан техник, технологийн дэвшил, шинжлэх ухааны ололтыг ашиглах,
- Эзэмшил ашиглалтанд байгаа боловч ашиглаагүй талбайг бүрэн ашиглах, мөн тариалангийн талбай байсан боловч цөлжиж, хөрсний үржил шим нь доройтолд орсон талбайг төсөл сонгон шалгаруулж нөхөн сэргээх замаар хүнсний ногоо тариалж эргэлтэнд оруулах.
- Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын харилцан ойлголцлыг сайжруулж бие биеэ дэмжсэн хамтын ажиллагааг бий болгох.

Дөрөв.Хөтөлбөрийн зорилго

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь: Аймгийнхаа хүн амын хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангаж, нэр төрлийг олшруулж хангамжийг нэмэгдүүлж улсын хэмжээний хүнсний ногооны үйлдвэрлэлд эзлэх байр сууриа тогтвортой нэмэгдүүлж экологийн цэвэр, чанартай хүнсээр хүн ардаа хангах хүнсний ногооны үйлдвэрлэлийн техник, технологийн дэвшилтэт арга ажиллагааг нэвтрүүлж механикжуулах хүнсний ногоо эрхэлдэг иргэн, айл өрх, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгож оршино.

Тав. Хөтөлбөрийн зорилт

5.1.Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ.

1. Хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх.
2. Хүнсний ногооны нутагшсан сортын үр үржүүлэх, үр үржүүлэх тусгай зөвшөөрөл бүхий үр үржүүлсэн иргэд, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх,
3. Шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж гар ажиллагааг хөнгөвчилөх, хүнсний ногооны бага оврын техник тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх
4. Шинэ нэр төрлийн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хэрэгцээг хангах, гадаад дотоодын зах зээлд борлуулан өрхийн орлогыг нэмэгдүүлэн цаашид импорттой өрсөлдөх чадварыг нь сайжруулах
5. Хөтөлбөрийн ач холбогдлыг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, сургалт мэдээ мэдээллийн баазыг бэхжүүлэх.

Зургаа. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйлажиллагаа

Нэгдүгээр зорилтын хүрээнд

6.1.1.Сум бүр хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ИТХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх тухай жил бүрийн төсөв, хөрөнгө оруулалтыг

6.1.2.Аймаг, сумдад салбар зөвлөл байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлан, мэдээг аймгийн салбар зөвлөлд ирүүлж байх.

6.1.3.Хүнсний ногоо тариалсан талбай, хураасан ургац, үйлдвэрлэж боловсруулсан бүтээгдэхүүнд нь урамшуулал олгох саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх

6.1.4.Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч иргэдийг даатгалд бүрэн хамруулж хэвшүүлэх

6.1.5.Нөхөрлөл,хоршоо, бүлгийн хэлбэрээр хүнсний ногоо тариалж буй иргэд аж ахуй нэгжид жижиг, дунд үйлдвэрийн зээлийг давуу эрхээр олгох

6.1.6.Газрын тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж эрдэм шинжилгээний байгууллагаар 3 жил тутам хөрсний шинжилгээг хийлгэж картограмийг гаргуулах

6.1.7.Хүнсний ногооны талбайн ашиглалтыг сайжруулах

Хоёрдугаар зорилтын хүрээнд

6.2.1.ХААИС, УГТСЭШХ болон бусад шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллаж орон нутгийн онцлогт тохирсон хүнсний ногооны сортын үрийг сонгон тарьж ургуулах технологийг шинэчилэн боловсруулах

6.2.2.Орон нутгийн онцлогт тохирсон нутагшсан сортын үр үржүүлэх санал, санаачилгыг дэмжих

6.2.3.Хүнсний ногооны үрийн аж ахуйг хөгжүүлэх

6.2.4.Үр үйлдвэрлэсэн иргэн, аж ахуйн нэгжүүдэдийг урамшуулах

6.2.5.Хүнсний ногооны үр үржүүлэгчидийн үрийн талбайд мэргэжлийн байгууллага болон улсын байцаагчаар хянан баталгааг хийлгүүлж, чанарын баталгаатай хүнсний ногооны үрээр хангах

Гуравдугаар зорилтын хүрээнд

6.3.1.Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд бага оврын техник, тоног төхөөрөмж,услалтын систем, хүлэмж, хүлэмжийн нийлэг хальсийг олж нийлүүлэн гар ажиллагааг хөнгөвчлөх

6.3.2.Сум дундын болон томоохон сумдад хүнсний ногооны талбайн хэмжээг харгалзан техник үйлчилгээний дундын парк байгуулах

6.3.3.Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд ялангуяа өвлийн хүлэмжийн аж ахуйг эрхлэхэд түлхүү анхаарч бүх талын дэмжлэг үзүүлэх

6.3.4.Хүнсний ногоо дахин боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх

6.3.5.Ургамал хамгааллын болон ургалтыг идэвхжүүлэгч бодис биологийн гаралтай бордооны хэрэглээг нэмэгдүүлэх

6.3.6.Зоорины аж ахуйг өргөжүүлж хагас механикжсан хэлбэрт оруулах

6.3.7.Хөрсний үржил шимийг сайжруулах нөхөн сэргээх, элсний нүүдлээс хамгаалах цөлжилтийг сааруулах чиглэлээр хүнсний ногоо жимс, жимсгэнэ тариалах санаачлагыг бүх талаар дэмжих.

6.3.8.Хүнсний ногоо эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн ургацад хянан баталгаа хийж, зах зээлд борлуулах нөхцлийг бүрдүүлэх.

6.3.9.Жил бүр төсөл хөтөлбөрүүдэд хамруулах замаархүнсний ногооны талбайг бүрэн хашуужуулах арга хэмжээ авах

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд

6.4.1.Хүнсний ногоо түүгээр боловсруулсан бүтээгдэхүүнийг жилийн турш борлуулах борлуултын сүлжээг бий болгох

6.4.2.Сав баглаа боодол, нэр хаягийг стандартын шаардлагад нийцүүлж импорттой өрсөлдөх хэмжээнд хүргэх

6.4.3.Уламжлал болгон жил бүр зохион байгуулагддаг “Алтан намар”, “Сэлэнгийн ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж бүх ногоочдыг идэвхитэй жигд оролцуулах

6.4.5.Цэцэрлэг сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувилал бусад төсвийн газруудыг дотоодын үйлдвэрлэлийн стандарт, чанарын шаардлага хангасан хүнсний ногоо, үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнийг өргөн хэрэглэжхэвшүүлэх

6.4.6.Хүнсний ногоо тариалагчдын шинэ ургацын ногоог борлуулах зах зээлд нь ойр хадгалах нэгдсэн зоорийн аж ахуйн асуудлыг холбогдох газруудтай хамтран шийдвэрлэх.

6.4.7.Бүх сумд хүнсний ногоо боловсруулах үйлдвэртэй болоход дэмжлэг үзүүлэх

Тавдугаар зорилтын хүрээнд

6.5.1.Хөтөлбөрийн ач холбогдлыг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах

6.5.2.Хүнсний ногоо түүний зохистой хэрэглээ болон бүтээгдэхүүний чанарыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах

6.5.3.Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвийг түшиглэн иргэд, аж ахуйн нэгжүүдийн туршлага, санаачлагыг дэлгэрүүлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчилах, тэргүүн туршлагын ном сэтгүүл гаргах

6.5.4.Хүнсний ногооны аж ахуй эрхлэгч болон үйлдвэрлэгчдийг харилцан туршлагыг нь солилцуулах арга хэмжээ авах

6.5.5.МСҮТ- тэй хамтран түргэвчилсэн сургалт зохион байгуулж мэргэжлийн боловсон хүчнээр хангах ,чадваржуулах

6.5.6.Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэргэжлийн удирдлага менежментийг сайжруулах төрөл бүрийн сургалт зохион байгуулж мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангах

6.5.7.Шинэ технологи болон орчин үеийн трактор болон тоног төхөөрөмжийн талаар сургалтуудыг зохион байгуулах

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

7.1. “Хүнсний ногоо” аймгийн хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2016 он хүртэл хэрэгжүүлнэ.

7.2.1 үе шат 2012-2014 он

7.2.1. Хөтөлбөрийг сурталчилж олон нийтэд таниулах.

7.2.2.Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хамгаалагдсан хөрсөнд хүнсний ногоо тариалах нөхцлийг бүрдүүлж, тариалах арга технологийг эзэмшүүлэх.

7.2.3.Хүнсний ногооны нэр төрлийг олшруулан 15-25 нэр төрлийн таримал тариалах.

7.2.4.Хүнсний ногооны талбайн хэмжээг 2250 га-д хүргэж, 200-гаас доошгүй ажлын байр нэмэгдүүлэх.

7.2.5. Аймагтаа хүнсний ногоо боловсруулах үйлдвэр, цех байгуулж, стандартын шаардлагад нийцсэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх.

7.3. II үе шат 2014-2016 он

7.3.1. Хүнсний ногоо тариалах талбайг 2350 га-д хүргэж хураан авах ургацыг нэмэгдүүлнэ.

7.3.2. Бүх сумдад хүнсний ногооны боловсруулах үйлдвэр, цехтэй болж, үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний ногооны хэрэглээг 20 хувьд хүргэх.

7.3.3. Стандартын шаардлагад нийцсэн экологийн цэвэр нэрийн бренд бүтээгдэхүүнийг бий болгож, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

7.3.4. 300-аас доошгүй ажлын байр шинээр бий болгоно.

7.3.5. Аймгийн хүн амын төрөл бүрийн хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангаж улсын хэрэгцээт хүнсний ногооны 40-өөс доошгүй хувийг үйлдвэрлэж, нийлүүлнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

8.1. Аймаг, сумдыг Засаг дарга нар тус тусын нутаг дэвсгэрт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

8.2. Хүнс, хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн газар нь мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж дэмжлэг тусалцаа үзүүлж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэгтэй оролцоно.

8.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг жил бүр төлөвлөж үндсэн чиглэлд тусган, шаардагдах төсвийг тухайн оны төсөвт суулгаж хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож байна.

8.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж байна.

Ес. Хөтөлбөрийн санхүүжилт

9.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

9.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө

9.3. Жижиг дунд үйлдвэрийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох хөрөнгө

9.4. Олон улсын байгууллагын зээл, буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө

9.5. Бусад эх үүсвэр

Арав. Хүлээгдэж байгаа үр дүн

10.1. Хүнсний ногооны тариалалтын талбай 200 га талбайгаар нэмэгдсэн байна.

10.2. Таримлын төрлийг олшруулж 15-25 нэр төрлийн ургамал тариалдаг болж аймгийнхаа хэрэгцээт хүнсний ногоог 100 хувь, улсын хэрэгцээт хүнсний ногооны 40-өөс доошгүй хувийг хангана.

10.3. Хүнсний ногооны аж ахуй эрхлэгчидийн тоо өсөж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа өргөжиж механикжилтийн түвшинг 40 хувиар нэмэгдүүлнэ.

10.4. Шинэ дэвшилтэд техник технологи нэвтрүүлж, гол нэр төрлийн хүнсний ногооны үрээр өөрсдийн хэрэгцээг хангана.

10.5. Аймгийн хэмжээнд сум бүр боловсруулах үйлдвэр, цехтэй болсон байна.

10.6. 500-аас доошгүй ажлын байр шинээр бий болно.

10.7. Борлуулалтын таатай нөхцөл бүрдэж ногоочдын орлого нэмэгдэнэ.

_____оОО_____

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 26-ны өдөр

Дугаар 126

Сүхбаатар

Сум дундын ойн анги байгуулах тухай

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 255 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ерөөгийн бүсийн сум дундын ойн ангийг Ерөө суманд, Хараагийн бүсийн сум дундын ойн ангийг Мандал суманд, Орхоны бүсийн сум дундын ойн ангийг Баруунбүрэн суманд, Бэлчир-Сэлэнгийн бүсийн сум дундын ойн ангийг Сүхбаатар суманд тус тус байршуулан байгуулсугай.

2.Сум дундын ойн ангиудын харьяалах сум, хамаарах нутаг дэвсгэр, хариуцах талбайн хэмжээг 1 дүгээр хавсралтаар, сум дундын ойн ангийн дүрмийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сум дундын ойн ангийн бүтэц, орон тоог батлан мөрдүүлж, төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргад, ажиллах нөхцөл боломжоор хангахыг Ерөө, Мандал, Баруунбүрэн, Сүхбаатар сумдын Засаг дарга нарт, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2012 оны 12 дугаар сарын 26-ны
өдрийн 126 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН БАЙРШИЛ, ХАРИУЦАХ
ТАЛБАЙ, ХАМРАХ СУМДЫН ЖАГСААЛТ**

Нийт талбайн хэмжээ /мянган га/	Сум дундын ойн ангийн байршил	Хариуцах ойн талбай /мянган га/	Хамрах сумдын нэр
1931,2	Ерөө	695,2	Ерөө, Хүдэр, Жавхлант
	Мандал	388,1	Мандал, Баянгол
	Баруунбүрэн	474,9	Баруунбүрэн, Сайхан, Орхон, Хушаат, Сант, Орхонтуул
	Сүхбаатар	372,8	Алтанбулаг, Шаамар, Түшиг, Зүүнбүрэн, Цагааннуур

_____оОо_____

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН ДҮРЭМ

Í ŷă Í èéðëŷă ĺí äŷñëŷë

1.1.Сум дундын Í éí àí æí ü Í éí òõðäé õóóëŷ болон холбогдох бусад хууль тогтоомж, ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх òàèààð ò°ð çàññàññ ãðñññàí áí äëí ã , ø èéäâŷðëéä õŷðŷæĺëŷð чиг үүрэг áĺðëé албан газар байна.

1.2.Сум дундын ойн ангийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр байгуулна.

1.3.Сум дундын ойн áí æ í ü ĺéé àæèèèàññáí ààà Ì í í ã è Ÿëñüí Бàéæëü ì ð÷í ü ã òàí ãàèàð òõðäé áí ëíí Í éí òõðäé õóóëü, áóñàà õóóëü òí ãñíí æ ŷí ŷðĺ äĺðì èéãóäèðäèàññ áí ëíí .

1.4.Сум дундын ойн áí æ í ü òí ãñíí ñíí æððì ààð ĺééäñŷí òŷí äŷă äŷëŷäŷë, àèáàí àè÷æéí òŷäëŷí ŷë õóóàññòàè áàéí à.

ÕĲ , ð. Сум дундын ойн ангийн нэр хаяг байршил

2.1 Оноосон нэр:Ерөөгийн бүсийн сум дундын ойн анги

Байршил: Ерөө сумын төв

2.2. Оноосон нэр: Хараагийн бүсийн сум дундын ойн анги

Байршил: Мандал сумын төв

2.3 Оноосон нэр: Бэлчир-Сэлэнгийн бүсийн сум дундын ойн анги

Байршил: Аймгийн төв Сүхбаатар сум

2.4 Оноосон нэр: Орхоны бүсийн сум дундын ойн анги

Байршил: Баруунбүрэн сумын төв

Гурав.Сум дундын Í éí àí æéí ĺéé àæèèèàññáí ü ÷èæŷë

Сум дундын ойн áí æ í ü аймгийн Байгаль орчны бүрэлдэхүүнд багтаж ì ŷðŷæèéí óäèðäèàññ äí ð ñòí üí Çàñàà ààðññí ŷððëŷð àæëüí òĺðŷŷí ä °°ðëéí òàðèòõñáí í óàãäŷŷñŷðð äí ð äóðññáí ĺéé àæèèèàññäŷäóóéí à.

[illegible]

3.4.Î éí ààÿëæéí í°°òèéã òĩ ìòî ò áóp ó ñóààèæà ÿáoóéàð çàðèèèæà °æ ò, çð äçí ãðçëÿÿí àààð.

3.6.1 Ì à áyèdàyò òàèààéà òòñààdèàò, ì éà òàdùàè òdàòòèàò, ṽ àí òí àòí é áyèdàyò, òàdùò ñòóèàò àí éàòòèàò, ì éà àd+èèàà, òyáyòèyáyí èé àdàà òyí àyý àà- yàòòèàòúí cyòyàyy òòòàéí ìéí ñàí àéí í°òèéí ṽíyèyá yòò áṽòèé ì yòyàèèéí ààéàòòèèààòàé òàì òdàí òèéò.

3.8. Õàðèóñàì í òòãã áýãñýðòýý î é, àì æéí ààyëæéí °° ð÷è° èðéí àææàèð
ðéeæ ì ýáýýài ýáýýèèéí ñàì ä òõñðóéàð.

3.10. Ɔ̀ðeéí yðō áçðeé ààéñðōēēāñí ðēēāāyðýýð òí āí ðōí é àæē çðæēā
āyðýí ēē çí āñýí āýýð āçēyōāyō.

3.12.Í éí áàÿèæéãõĩ ãõĩ ðõĩ é àø èæàõ, ðàì æàèàõ, í °õ í ñýðäÿýð òàèààð î éí ðóóèù òĩ ãõĩ î ì æé à çààñàì ççðäÿý äèéõýðäÿýä í ü ñòì ú í Çàñàã ààðæà ì ýðäÿæèéí ç° âèøð°, äÿì æéÿä ççèÿõ, ì ýäÿýèéÿýð ðàì æàð.

3.13.Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас $\circ\tilde{a}\tilde{n}\tilde{o}\tilde{i}$ $\div\tilde{e}\tilde{a}\tilde{y}\tilde{e}$, $\tilde{o}\tilde{a}\tilde{e}\tilde{d}\tilde{a}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{o}\tilde{y}\tilde{d}\tilde{y}\tilde{a}\tilde{e}$ $\tilde{z}\tilde{e}\tilde{y}\tilde{o}\tilde{y}\tilde{a}$ $\tilde{i}$ $\tilde{d}\tilde{i}$ $\tilde{e}\tilde{o}\tilde{i}$ $\tilde{o}$, $\tilde{a}\tilde{y}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{y}\tilde{a}$ $\tilde{z}\tilde{c}\tilde{z}\tilde{e}\tilde{y}\tilde{o}$.

3.14. $\tilde{i}$ $\tilde{e}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{y}\tilde{e}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{o}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{o}$, $\tilde{i}\tilde{o}\tilde{i}$ $\tilde{n}\tilde{y}\tilde{d}\tilde{a}\tilde{y}\tilde{o}$, $\tilde{c}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{n}\tilde{o}\tilde{i}$ $\tilde{e}$ $\tilde{a}\tilde{o}$ $\tilde{e}\tilde{a}\tilde{a}\tilde{o}$ $\tilde{o}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{a}\tilde{d}$ $\tilde{o}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{u}$ $\tilde{o}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{n}\tilde{i}$ $\tilde{i}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{a}$ нийцүүлэн $\tilde{z}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{a}\tilde{y}\tilde{d}\tilde{e}\tilde{y}\tilde{e}$, $\tilde{z}\tilde{e}\tilde{e}\div\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{y}\tilde{y}$ $\tilde{y}\tilde{d}\tilde{o}\tilde{e}\tilde{y}\tilde{o}$.

3.15. $\tilde{m}\tilde{i}$ $\tilde{a}$ $\tilde{a}\tilde{y}\tilde{e}\tilde{o}\tilde{a}\tilde{y}\tilde{o}$ $\tilde{y}\tilde{d}\tilde{o}$ $\tilde{a}\tilde{z}\tilde{o}\tilde{e}\tilde{e}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{d}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{i}$ $\tilde{y}\tilde{a}\tilde{e}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{a}\tilde{u}$ $\tilde{a}\tilde{c}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{o}$ $\tilde{a}\tilde{o}\tilde{d}\tilde{i}$ $\tilde{u}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{a}\tilde{o}$ $\tilde{i}\tilde{o}\tilde{i}$ $\tilde{n}\tilde{y}\tilde{d}\tilde{a}\tilde{y}\tilde{e}\tilde{o}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{y}\tilde{l}\tilde{e}\tilde{x}$, $\tilde{z}\tilde{e}\tilde{e}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{a}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}$ $\tilde{o}\tilde{y}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{o}$ $\tilde{o}\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{o}$.

3.16.Эрх бүхий байгууллагын хуваарь, зөвшөөрлөөр харьяалах сумдад бэлтгэх модны тодорхой хэсгийг бригад зохион байгуулан бэлтгүүлж тухайн сумын иргэдийн хэрэгцээнд нийлүүлэх.

3.17. $\tilde{o}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{n}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}$ $\tilde{y}\tilde{c}\tilde{y}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{a}\div\tilde{i}\tilde{o}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{o}$ $\tilde{e}$, $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{d}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{i}$ $\tilde{y}\tilde{a}\tilde{e}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{a}$, $\tilde{e}\tilde{d}\tilde{a}\tilde{y}\tilde{a}\tilde{y}\tilde{a}$ $\tilde{i}$ $\tilde{e}\tilde{a}$ $\tilde{o}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{o}$, $\tilde{c}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{n}\tilde{o}\tilde{i}$ $\tilde{e}$ $\tilde{a}\tilde{o}$ $\tilde{e}\tilde{a}\tilde{a}\tilde{o}$, $\tilde{i}\tilde{o}\tilde{i}$ $\tilde{n}\tilde{y}\tilde{d}\tilde{a}\tilde{y}\tilde{o}$, $\tilde{z}\tilde{d}\tilde{a}\tilde{z}\tilde{e}\tilde{y}\tilde{o}$ $\div\tilde{e}\tilde{a}\tilde{y}\tilde{e}\tilde{y}\tilde{y}\tilde{o}$ $\tilde{n}\tilde{o}\tilde{d}\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{o}$, $\tilde{n}\tilde{o}\tilde{d}\tilde{o}\tilde{a}\tilde{e}\div\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{a}$ $\tilde{y}\tilde{a}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{a}\tilde{o}$.

3.18. $\tilde{o}\tilde{e}\tilde{a}$ $\tilde{o}\tilde{z}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{y}\tilde{d}$, $\tilde{o}\tilde{i}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{o}$ $\tilde{o}\tilde{a}\tilde{a}\tilde{a}\tilde{e}$ $\tilde{o}\tilde{a}\div\tilde{e}\tilde{i}$ $\tilde{c}\tilde{y}\tilde{d}\tilde{y}\tilde{a}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{e}\tilde{e}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{y}\tilde{i}$ $\tilde{y}\tilde{o}\tilde{e}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{p}\tilde{o}\tilde{e}$, $\tilde{a}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{a}\tilde{a}\tilde{n}$ $\tilde{o}\tilde{d}\tilde{u}\tilde{a}\div\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{n}\tilde{y}\tilde{d}\tilde{a}\tilde{e}\tilde{e}\tilde{y}\tilde{o}$, $\tilde{o}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{o}$, $\tilde{o}\tilde{y}\tilde{a}\tilde{a}\tilde{y}\tilde{y}\tilde{d}\tilde{o}\tilde{y}\tilde{e}$ $\tilde{o}\tilde{y}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{y}\tilde{o}$ $\tilde{a}\tilde{d}\tilde{a}\tilde{a}$ $\tilde{o}\tilde{y}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{y}\tilde{y}\tilde{a}\tilde{o}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{i}$ $\tilde{d}\tilde{i}$ $\tilde{i}$ $\tilde{i}$ $\tilde{o}\tilde{a}\tilde{a}\tilde{d}$ $\tilde{o}\tilde{y}\tilde{d}\tilde{y}\tilde{a}\tilde{e}$ $\tilde{z}\tilde{e}\tilde{y}\tilde{o}$.

3.19. $\tilde{o}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{n}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}$ $\tilde{y}\tilde{c}\tilde{y}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{a}\div\tilde{i}\tilde{o}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{o}$ $\tilde{e}$, $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{d}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{i}$ $\tilde{y}\tilde{a}\tilde{e}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{a}\tilde{u}$ $\tilde{i}$ $\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{o}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{o}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{e}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{e}\tilde{y}\tilde{e}\tilde{o}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{o}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{o}\tilde{o}\tilde{e}\tilde{a}$ $\tilde{c}\tilde{o}\tilde{d}\div\tilde{e}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{a}\tilde{d}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{o}$.

3.20. $\tilde{a}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{A}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{e}\tilde{u}$ $\tilde{i}$ $\tilde{d}\div\tilde{i}\tilde{n}$, аялал жуулчлалын газрын дэргэдэх $\tilde{i}$ $\tilde{e}\tilde{i}$ албанд $\tilde{o}\tilde{o}$ $\tilde{o}\tilde{e}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{z}\tilde{e}\tilde{e}$ $\tilde{a}\tilde{a}\tilde{e}\tilde{e}\tilde{a}\tilde{a}\tilde{a}\tilde{d}\tilde{a}\tilde{e}$ $\tilde{o}\tilde{i}$ $\tilde{e}\tilde{a}\tilde{i}$ $\tilde{i}$ $\tilde{o}\tilde{i}$ $\tilde{e}$ $\tilde{i}$ $\tilde{y}\tilde{a}\tilde{y}\tilde{y}\tilde{e}\tilde{e}\tilde{i}\tilde{y}\tilde{g}$ $\tilde{o}\tilde{o}\tilde{d}\tilde{a}\tilde{e}$ $\tilde{a}\tilde{z}\tilde{d}$ өгч байх

3.21.Ойн арчилгааны гэрэлжүүлэх, тохируулах огтлолтыг гүйцэтгэх болон харьяа сумдын ойн хөтөлбөр, ойн мэргэжлийн байгууллагуудын ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж хангуулах.

3.22.Аймаг, сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох.

3.23.Мэдээллийн санг эрхлэх.

3.24.Ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд сумын нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах.

Дөрөа. Сум дундын $\tilde{i}$ $\tilde{e}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{o}\tilde{a}\tilde{e}\tilde{d}\tilde{a}\tilde{e}\tilde{a}\tilde{a}$, $\tilde{y}\tilde{d}\tilde{o}$ $\tilde{o}\tilde{y}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{y}\tilde{y}$.

4.1.Сум дундын $\tilde{i}$ $\tilde{e}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{e}\tilde{e}\tilde{i}$ $\tilde{a}\tilde{z}\tilde{o}\tilde{y}\tilde{o}$,орон тоог аймгийн Засаг дарга тогтооно.

4.7. ʼéé àæèèèàæàí ü çð äçí ä î èñí í àð æàñ òí æîí î ñí í æòðì üí ààæó °ðò çèäýýæ çàðèðàí çàðòóóèàð.

Тав. Сум дундын ойн аí æéí ñàí õççæèð, °ì ÷, ð° ð° í æ°.

Сум дундын Ойн ангиийн төсөв нь улсын төсөв түүнчлэн сургалт, арга зүйн зөвлөгөө үзүүлсний болон өөрийн ажил, үйлчилгээний орлого зэрэг эх үүсвэрээс санхүүжих.

5.1 Áí æéí ñàí õççæèð í ü äí ð äóðàñàí ýð ççñäýðýð äçðäýí ý. ʼçí ä:

à. Áàéæèèéí í °ð äð èæàñí ü ð éá°ðèéí î ðèí æ î ñ òí îí æ áàéæèèü î ð÷í ü ä òàí æàèàð, í °ð°í ñýðäýð äðæ òýì æýýí ä çí ðèóèàí ýðð äçðèé áàéæóóèèæàñ òóñ áàéæóóèèæà çàðòóóèàðü äç° äð °ð÷ î èæí ñí í ð° ð° í æ°.

á. Òðèéí çàðèì ççðæéäæéöýðäýñí èé ð° è° ð° ð° ñ î èæ ð ð ñàèéí ð° ð° í æ°.

â. Òð ñ° è öýðýæççèñí èé çð äçí äýñí î ðí ð î ðèí æ°.

ã. Сум дундын ойн аí æéí àæè, çèè÷èèäýýí ýýñí î ðí ð î ðèí æ°.

ä. Õóóèèàð õí ðèæí î æé °ðèéí çèè àæèèèàæàí ààñ î ðí ð î ðèí æ°.

å. Áóñàä î ðèí æ°.

5.2 Сум дундын Ойнаí æè í ü °ðèéí ì ýäèèéí °ì ÷ ð° ð° í æ° öýé áàéæ òççí èéäýý õí éáí æàí ð ðóóèü, õí æîí îí æéí ààæó çàðèðàí çàðòóóèí à.

Хэвлэлд бэлтгэсэн: О.Буянтогтох
Эмхтгэсэн: Ш.Баярмаа